

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

“ОРОН СУУЦ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

2018 оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.4.77.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Орон сууцны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн, Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Орон сууц үндэсний хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Орон сууц” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгаж, гадаадын зээл, тусламжид хамруулан, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 01-ний дотор Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, дүнг нэгтгэн жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газарт танилцуулж байхыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд тус тус үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Барилга, хот байгуулалтын сайд

Х.БАДЕЛХАН

“ОРОН СУУЦ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
(2018-2023)

Нэг. Нийтлэг үндэслэл

Тохилог сууцанд амьдарч, тогтвортой ажил эрхлэх нь хүний нийгмийн үндсэн хэрэгцээ билээ.

Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын дүнгээр улсын хэмжээнд нийт 859,1 мянган өрх тоологдсоны 389,9 мянган өрх буюу нийт өрхийн 45,4 хувь нь уламжлалт сууц - гэрт, 465,3 мянган өрх буюу 54,2 хувь нь байшинд, 3,9 мянган өрх буюу 0,4 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

Манай улсад 2017 оны байдлаар нийт 885 639 өрх амьдарч байгаагаас, нийслэлд 240200 өрх, орон нутагт 57100 өрх инженерийн бүрэн хангамжтай тохилог орон сууцанд амьдарч байна.

Хотод байшинд амьдардаг өрхийн 40,6 хувь, хөдөөд байшинд амьдардаг өрхийн 85,7 хувь нь ердийн галлагаагаар халаалтаа шийдэж байна.

Улсын хэмжээнд нийт өрхийн 2,5 хувь буюу 21,5 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байна. Эдгээрийн 10,1 мянга нь хотын өрх байна.¹

Хөдөө, орон нутагт орлогын ядуурал гүнзгийрсэн, ажил эрхлэлт буурсантай холбоотойгоор зах зээлийн эрэлтийг даган ажлын байртай болох, эрүүл мэнд, эмнэлэг, сургууль, соёлын үйлчилгээнд ойртох зорилгоор төв суурин газарт иргэд олноор шилжин суурьших болсонтой холбоотойгоор төлөвлөлт, зохицуулалтгүйгээр гэр хороолол ихээхэн нэмэгдэж байна.

Төлөвлөлтгүйгээр өсөн нэмэгдэж байгаа хотжилт, дэд бүтцийн хүртээмжгүй байдал нь төв суурин газрын хөрс, ус, агаарын бохирдлыг үлэмж нэмэгдүүлж, ард иргэдийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна.

Судалгаагаар, нийслэлийн агаарын бохирдлын эх үүсвэрийн 80,0 хувийг гэр хорооллын яндангаас гарах утаа, 5,0-6,0 хувийг дулааны цахилгаан станцуудаас ялгаруулж буй утаа, 10,0 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа автотээврийн хэрэгслэлээс ялгарч буй утаа, угаарын хий, 4,0 хувийг бусад эх үүсвэрээс ялгарч буй утаа, тоосжилт эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд барилгын салбарын үйл ажиллагаа эрчимжиж, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хандивлагч орнуудын зээл, тусламж, захиалагч иргэдийн өөрсдийн санхүүжилтээр орон сууцны барилгууд олноор баригдаж ашиглалтад орж байгаа хэдий ч бага, дунд орлоготой иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцны нийлүүлэлт хомс байна.

Хүн амын дийлэнх хэсэг, түүний дотор залуу гэр бүл, төрийн албан хаагчид, бага, дунд орлоготой иргэдэд өөрсдийн хөрөнгө хүчээр орон сууц барих, худалдан авах, орон сууцныхаа нөхцлийг сайжруулах боломж хязгаарлагдмал байна.

¹ Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын дүн

Үндэсний статистикийн хорооны “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал”-ын судалгаагаар 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд ажилгүй иргэд 100,3 мянга, ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай ядуу өрх 174,8 мянга байна.

Монгол Улсын нийт хүн амын 33,7 хувь нь 15-34 насны залуучууд, 5,9 хувь нь төрийн албан хаагчид байгаа бөгөөд гэр бүлтэй залуучуудын дийлэнх, төрийн албан хаагчдын 40,0 хувь нь өөрийн эзэмшлийн орон сууцгүй байна.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулах хүрээнд орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн судалгааг улсын хэмжээнд хийж гүйцэтгүүлсэн бөгөөд уг судалгаагаар, ирэх 5 жилийн хугацаанд нийслэлд 217 000 өрх, орон нутагт 120 000 өрх инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох хэрэгцээтэй байгаагийн нийслэлд 33 100, орон нутагт 11 700 өрх нь худалдан авах чадвараар баталгаажсан эрэлттэй байна.

Зах зээл дээр борлуулагдаж байгаа орон сууцны үнэ өндөр, иргэдийн худалдан авах чадвар муу байгаа өнөө үед иргэд орон сууц худалдан авахаас илүүтэйгээр хямд түрээсийн төлбөр төлж, орон сууцыг урт хугацаанд түрээсэлж, уг сууцны өөрийн өртгийг нөхөх замаар өөрийн өмчлөлийн сууцтай болох, түрээслэнгээ урьдчилгаа төлбөрөө бүрдүүлж, орон сууцны ипотекийн зээлд хамрагдан худалдан авах замаар өөрийн өмчлөлийн орон сууцтай болох эрэлт, хэрэгцээ өндөр байна.

Нийслэлд 73336 өрх, орон нутагт 37266 өрх өөрийн өмчлөлийн газартаа инженерийн хангамж бүхий амины орон сууц барих, нийслэлд 44747 өрх, орон нутагт 32048 өрх орон сууц түрээслэн амьдрах хэрэгцээтэй байна.²

Дээр дурьдсан хэрэгцээ, шаардлагыг харгалзан, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.77.1-д “Орон сууц” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх”-ээр заасныг үндэслэн Улсын Их Хурлын 1999 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичиг, Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”, Орон сууцны тухай хууль болон Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор холбогдох бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд төв, суурин газрын өрхүүдийн дийлэнх олонхийг инженерийн бүрэн хангамжтай, ногоон барилгын шийдэл бүхий орон сууцаар хангахаар тооцвол, 6,0 мянган м² талбай бүхий 120,0 мянган орон сууцыг барьж нийлүүлэх тооцоо гарч байгаа бөгөөд дор хаяж, 7,800,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, хөтөлбөр хэрэгжих хугацаанд жил бүр 1,560.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

² Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ, “Тэнхлэг зууч” ХХК-ийн түншлэлийн 2018 онд хийсэн судалгаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Төв, суурин газарт амьдардаг өрхүүдийн дийлэнх олонхийг тэдний худалдан авах чадварт нийцсэн, орчин үеийн чанар, стандартын шаардлага хангасан, монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон, инженерийн бүрэн хангамжтай, ногоон барилгын шийдэл бүхий орон сууцаар хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 1. Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

Зорилт 2. Гэр хорооллын газрыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай дэд бүтэц бүхий ногоон барилгын шийдэл бүхий амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

Зорилт 3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжинэ.

Зорилт 4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байнгын асаргаа шаардах хүүхдийг халамжилдаг эсхүл 0-18 насны 4 ба түүнээс олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон эцэг, эх, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцлийг эрс сайжруулна.

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат (2018-2019 он): Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хангахад чиглэсэн хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.

Хоёрдугаар үе шат (2020-2023 он): Шинэчлэгдсэн хууль, эрх зүйн орчинд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг бүрдүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагаа

3.1.Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад чиглэсэн санхүүжилтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

3.1.2.түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

3.1.3.орон сууцны даатгалын тогтолцоог боловсронгуй болгох.

3.2. Гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн хангамжтай, ногоон барилгын шийдэл бүхий амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.гэр хорооллын өмчилсөн эдэлбэр газрыг тухайн газрын эздийн шууд оролцоотойгоор дахин төлөвлөж, газрыг зүй зохистой ашиглах хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.2.2.төв, суурин газрын гэр хорооллыг суурин амьдралын нөхцөл, стандартыг бүрэн хангасан монгол дүр төрх бүхий сайжруулсан гэр, амины сууцны хороолол болгон хөгжүүлэх;

3.2.3.инженерийн хангамжийн гол шугам сүлжээ, барилга байгууламжийг барих ажлыг төр хариуцаж, санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэн орон сууц болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж барих нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.4.өндөр технологийн бие даасан дэд бүтцийг дэмжиж хөгжүүлэх, инженерийн хангамжид сэргээгдэх эрчим хүч, инженерийн төвлөрсөн ба бие даасан эх үүсвэрийг хослуулан хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх;

3.3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.хот, суурин газрын хэт төвлөрлийг сааруулах, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дагуул, хаяа хот, тосгодыг жигд тэнцвэртэйгээр хөгжүүлж, иргэдийн орон сууцны хангамж, хүртээмжийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;

3.3.2.орон сууцны барилгын эрчим хүчний (цахилгаан болон дулааны) хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний хэрэглээг хэмнэлтийн тарифын бодлогоор дэмжих, тоолууржуулах замаар хэрэглээгээрээ төлдөг тогтолцоонд шилжих;

3.3.3.орон сууцны барилгыг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, холбогдох норм, дүрэм, стандартыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр инженер, техникийн ажилчдыг сургах, мэргэшүүлэх;

3.3.4.шинээр баригдах орон сууцны барилгын эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн хүчин чадлын тодорхой хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шийдвэрлэх;

3.3.5.ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарах, инженерийн хангамжид эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж, хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг бүх талаар дэмжих;

3.3.6.орон нутгийн засаг захиргаа, сууц өмчлөгчдийн оролцоотойгоор дулааны алдагдал ихтэй, угсармал орон сууцны барилгуудыг дулаалах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцны барилгуудыг буулган, шинээр барих төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3.3.7.эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны санхүүжилтийг дэмжих боломжит эх үүсвэрүүдийг судалж, нэвтрүүлэх;

3.3.8.циркуляр эдийн засаг (circular economy)-ийн загварт шилжих, орон сууцны барилгын хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох;

3.3.9.орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд хүртээмжтэй ил, далд авто зогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулсан ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчинг бүрдүүлэхэд онцгойлон анхаарах.

3.4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байнгын асаргаа шаардах хүүхдийг халамжилдаг эсхүл 0-18 насны 4 ба түүнээс олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон эцэг, эх, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцлийг эрс сайжруулах 4 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1.гадаад, дотоодын буцалтгүй тусламжийн тодорхой хувийг зорилтот бүлэг, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулахад зориулах;

3.4.2.“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 20000 айлын төрийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх;

3.4.3.ядуурлын түвшингээс доогуур орлоготой 0-18 насны 4-ээс дээш хүүхэдтэй гэр бүл, өрх толгойлсон эцэг /эх/, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг тэргүүн ээлжинд түрээсийн орон сууцаар хангах бодлого барих;

3.4.4.батлан хамгаалах, төрийн цэргийн байгуулал, эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсдыг орон сууцаар хангах арга хэмжээг тэдний цалин, орлогын түвшинтэй уялдуулан орон сууцны ипотекийн зээлийн уян хатан бодлогоор дэмжих;

3.4.5.төв, суурин газраас алслагдсан газар, нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, залуучууд, мэргэжилтэй боловсон хүчний ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны зээлийг түлхүү олгох, орон сууцаар хангах;

3.4.6.өрхийн амьжиргааг дэмжих, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бусад хөтөлбөр, төслийг ядуурлын түвшингээс доогуур орлоготой иргэдийг орон сууцаар хангах, тэдний орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээтэй уялдуулан зохицуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1.Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

4.1.1.төв, суурин газарт амьдардаг өрхүүдийн дийлэнх олонхи нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болж, агаар, хөрсний бохирдол буурсан байна;

4.1.2.зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны нөхцөл сайжирснаар, тэдний амьдрах, ажиллах урам зориг нэмэгдэнэ. Ажлын бүтээмж, амьжиргааны түвшин дээшилнэ;

4.1.4.төв, суурин газрын өнгө үзэмж сайжирна.

4.2.Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

4.2.1.эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөл зохих хэмжээнд хангагдснаар, ар гэр, үр хүүхдэдээ санаа зовохгүйгээр ажлаа хийх, амьжиргаагаа дээшлүүлэх боломж нэмэгдэнэ;

4.2.2.иргэдийн амьдрах орчин сайжирснаар эрүүл мэндийн улмаас учрах эдийн засгийн хохирол буурна;

4.2.3.орон сууцны салбарт ногоон үйлдвэрлэл, технологийг нэвтрүүлснээр эрчим хүчний нөөц хэмнэгдэх, үүнтэй уялдан иргэдэд хүрэх инженерийн хангамж үйлчилгээтэй холбогдсон зардал буурна;

4.2.4.иргэдийг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлж, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, үр ашигтай, хэмнэлттэй, ногоон хөгжлийн загварт нийцсэн үйлдвэрлэлийг бий болгосноор ажлын байр нэмэгдэнэ. Ингэснээр улс, орны эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлнө.

4.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

4.3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин
			2015 он	2023 он
Зорилго: Төв, суурин газарт амьдардаг өрхүүдийн дийлэнх олонхийг тэдний худалдан авах чадварт нийцсэн, орчин үеийн чанар, стандартын шаардлага хангасан, монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон, инженерийн бүрэн хангамжтай, ногоон барилгын шийдэл бүхий орон сууцаар хангахад хөтөлбөрийн зорилго оршино.				
1	Төв, суурин газарт амьдардаг өрхүүдийн дийлэнх олонхи нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болсон байна.	хувиар	25,3	66,6
2	Шинээр ашиглалтад орсон инженерийн бүрэн хангамжтай орон сууцны тоо	Айлын тоогоор	225 900	117000
Зорилт 1. Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.				
1	Орон сууцны салбарын эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100

2	Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100
3	Зорилтот бүлгийн иргэдэд орон сууц худалдан авах болон барих зориулалтаар олгох зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100
4	Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100
5	Орон сууцны ашиглалтын байгууллагуудын оновчтой бүтэц бий болсон байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100

Зорилт 2. Гэр хорооллын газрыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай дэд бүтэц бүхий ногоон барилгын шийдэл бүхий амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

1	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд шинээр баригдсан орон сууц	айлын тоогоор	4889	20 000
2	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд шинээр баригдсан амины орон сууцны тоо	айлын тоогоор	-	50 000
3	Шинээр баригдаж ашиглалтад орсон “Дэд бүтцийн төв”	тоо	-	200

Зорилт 3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

1	Шинэ сурьшил, дагуул, хаяа хот тосгодыг хөгжүүлэх хүрээнд шинээр ашиглалтад орсон орон сууцны тоо	айлын тоогоор	-	16226
1	Эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ, шошго авсан орон сууцны барилга	Барилгын тоо	-	20
2	Орон сууцны барилгыг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх чиглэлээр шинээр боловсруулсан норм дүрэм, стандарт	тоо	-	6
3	Орон сууцны барилгыг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, угсрах чиглэлээр	тоо	-	200

	мэргэшсэн инженер, техникийн ажилтан			
4	Нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилгыг дулаалах төсөлд хамрагдсан орон сууц	блок/айлын тоогоор	5/300	90/7300
5	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулган барих хүрээнд шинээр ашиглалтад орсон орон сууц	айлын тоогоор	301	3301
6	“Ногоон хувийн сууц” загвар төслийн хүрээнд ашиглалтад орсон орон сууц	айлын тоогоор	-	100
Зорилт 4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байнгын асаргаа шаардах хүүхдийг халамжилдаг эсхүл 0-18 насны 4 ба түүнээс олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон эцэг, эх, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцлийг эрс сайжруулна.				
1	Шинээр бүрдүүлсэн түрээсийн орон сууц	айлын тоогоор	1512	20 000
2	Зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулахад зориулсан төсвийн санхүүжилт	тэрбум төгрөг	-	7800
3	Шинээр инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болсон төрийн албан хаагчид	тоо	89000	75000
4	Түрээсийн орон сууцанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд	тоо	151	2000

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

5.1. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улс, орон нутгийн төсөв;

5.1.2. гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж;

5.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж, хөрөнгө оруулалт;

5.1.4. банк, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээл;

5.1.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга тухайн орон нутгийн орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

6.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэхүү хөтөлбөртэй нийцүүлэн тухайн орон нутгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад чиглэсэн дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж болно.

-----oOo-----